

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 50.11 дэх хэсэг нэмсүгэй:

“50 дугаар зүйлийн 50.11 дэх хэсэг:

50.11. Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгоно.”

2 дугаар зүйл: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“50 дугаар зүйлийн 50.12 дахь хэсэг:

50.12. Энэ хуулийн 50.10, 50.11, 50.12-т заасан нэмэгдэл, мөнгөн урамшил, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.

3 дугаар зүйл: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.11 дэх хэсгийн “50.11” гэснийг “50.12”, 50.12 дахь хэсгийн “50.12” гэснийг “50.13”, 50.13 дахь хэсгийн “50.13” гэснийг “50.14” гэж тус тус өөрчилсүгэй

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ